

“ХӨРӨНГӨ ОРЛОГЫГ ХУРААХ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ”

CHALLENGES IN IMPLEMENTING MEASURES TO REDUCE CAPITAL INCOME"



Э.Цэрэнханд

*Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны
403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны
сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн ахлах багш,
хууль зүйн магистр, хошууч*

Товч утга: Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн өнөөгийн байдлыг тодорхойлж, түүнд оногдуулж байгаа ял, албадлагын арга хэмжээнд дүн шинжилгээ хийж, энэ гэмт хэрэгтэй холбогдуулан гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тулгамдсан асуудлыг нээн илрүүлнэ.

Түлхүүр үгс: Гэмт хэрэг, улсын хил, эрүүгийн хариуцлага, ял, албадлагын арга хэмжээ, бараа, шүүхийн шийдвэр, хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ.

Удиртгал

Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал нь зөвхөн тухайн улсын дотоод асуудал бус бүс нутаг, олон улсын хэмжээний харилцааг хамарсан өргөн ойлголт болоод байна. Учир нь зарим төрлийн гэмт хэрэг улсын хил, олон улсын нутаг дэвсгэрт дамнан үйлдэгдэх төдийгүй, нийгэм, хүн амд асар их хор уршиг учруулдаг.

Энэ төрлийн гэмт хэргийн нэгд “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх” гэмт хэрэг зүй ёсоор хамаардаг ба 2012 онд АНУ-ын Нью Йорк хотод худалдаалагдсан “Тироннозавр Батаар” үлэг гүрвэлийн араг яс нь Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн болохыг олон улсын шинжээчийн баг нотолсон байдаг.

Монгол Улсын Их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг баталсан билээ. Тус үзэл баримтлалаар “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал,

үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана” гэж заасан⁸².

Үүнээс нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдлыг тусгайлан авч үзэх нь зүйтэй бөгөөд энэ агуулгад хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгох үзэл санааг тусгажээ.

Ингэснээр Монгол Улсын хилээр нэвтрэх аливаа бараа, эрдэнэс, эрдэс нь үндэсний аюулгүй байдалд харшлахаас урьдчилан сэргийлэгдсэн байх учиртай. Иймд хилээр буюу Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтэрч байгаа эсхүл гаргаж байгаа аливаа бараа нь олон улсын хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн, албан ёсны буюу захиргааны хэм хэмжээнд нийцсэн байхыг шаардана. Гэтэл энэ шаардлагыг зөрчсөн, хориглосон бараа улсын хилээр нэвтрэх гэмт хэрэг үйлдэгдэж, бүртгэгдсээр байгаа бөгөөд “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх” гэмт хэрэг 2020 онд 79 удаа, 2021 онд 53 удаа, 2022 онд 89 удаа, 2023 онд 22 удаа, 2024 онд 2 удаа буюу сүүлийн 5 жилийн байдлаар нийт 245 бүртгэгдсэн байна.

Эдгээр тоо нь энэ гэмт хэргийн улмаас учирч болох хор уршиг үлэмж хэмжээнд байгааг харуулж байна.

Үндсэн хэсэг

2012 оноос эхэлсэн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Монгол Улсын эрүүгийн хуулийг шинэ үзэл баримтлалтайгаар шинэчлэн боловсруулах ажил эхэлсэн. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад 2002 оны буюу өмнөх эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлд заасан “Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх”, 188 дугаар зүйлд заасан “Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх” гэмт хэргүүдийг нэгтгэж, эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлд “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх” гэмт хэрэг болгож өөрчилсөн.

Энэ нь эрүүгийн хуулийн өөр өөр бүлэгт хамаарч байсан нийгмийн аюулгүй байдлын эсрэг, эдийн засгийн эсрэг гэмт хэргүүд дэх нийтлэг шинж, гэмт хэргийн үйлдлийн арга зэргийг харгалзан нэгтгэж, тухайн гэмт хэргийн зүйлчлэлийн ач холбогдлыг нэмэгдүүлсэн юм.

“Эрүүгийн хууль”⁸³-д тус гэмт хэргийг хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу

⁸² Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол Улсын Их хурлын тогтоол. 2010. 48 дугаар тогтоол.

⁸³ Монгол Улсын Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2015.

хориглосон эсвэл хязгаарлалт тогтоосон барааг Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол гэж тодорхойлсон. Тодруулбал улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн буюу зохих зөвшөөрөлгүйгээр, гаалийн үзлэгээс гадуур, хилийн боомтгүй газраар, эсхүл гаалийн үзлэгээс нуун далдлах, тухайн эд зүйлийн нэр, төрөл, тоо хэмжээ, хэлбэр дүрс, баглаа боодлыг өөрчлөх, түүнчлэн гаалийн баримт бичиг болон гаалийн лац ломбыг хуурамчаар үйлдэх, засварлах, гаалийн мэдүүлэгт бичихгүй орхих буюу худал бичих зэрэг аргаар улсын хил болон эсвэл бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналт дор ачих, буулгах, шилжүүлэн ачих, хадгалах, тээвэрлэх, гаалийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон байр, агуулах, талбайгаар оруулсан, гаргасан, дамжин өнгөрүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйг заажээ⁸⁴.

Мөн энэ гэмт хэргийг албан тушаалын байдлыг ашиглах, байлдааны галт зэвсэг, галт хэрэгсэл, цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, тэсэрч дэлбэрэх бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний, амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдэх, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө зэргээр үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдалд тооцож ял шийтгэхээр тусгасан.

Эдгээр нь улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанарын хувьд үндэсний аюулгүй байдалд ч тодорхой нөлөө үзүүлж болохоор харагдаж байна.

Тэгвэл эрүүгийн хуульд энэ гэмт хэрэгт оногдуулж байгаа санкцыг өмнөх эрүүгийн хуультай харьцуулан авч үзье.

Хүснэгт 1. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх төрлийн гэмт хэрэгт оногдуулж ирсэн эрүүгийн хариуцлагын харьцуулалт 2002, 2015 оны эрүүгийн хуулийн хүрээнд

№	Ял	2002 оны Эрүүгийн хууль		2015 оны Эрүүгийн хууль
		175 дугаар зүйл “эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	188 дугаар зүйл “Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль	
				18.5 дугаар зүйл “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх”

⁸⁴ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй тусгай анги. УБ., 2018. 220 дахь тал.

			бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх”	
1	Торгох	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэн	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэн	451-400,000 нэгжээр
2	Албадан ажил хийлгэх/Нийтэд тустай ажил хийлгэх	251-500 цаг		240-720 цаг
3	Хорих	2-8 жил	25 жил хүртэл	1-12 жил
4	Баривчлах	3-6 сар	3-6 сар	
5	Зорчих эрхийг хязгаарлах			1 сараас 1 жил
6	Эд хөрөнгө хураах ял /2002 оны эрүүгийн хуульд/	эд хөрөнгө хураана		

Энэхүү харьцуулалтаас үзвэл 2015 оны эрүүгийн хуулиар “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх” гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь 2002 оны эрүүгийн хуулийн хоёр зүйлд заасан гэмт хэргийг нэгтгэсэн агуулгын хүрээнд оногдуулах ялын төрлийг нэмэгдүүлж, хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оногдуулахаар хуульчилжээ.

Иймд “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх” гэмт хэрэгт оногдуулах ял ба хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээний агуулга ач холбогдлыг тодруулах нь зүйтэй байна.

“Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх” гэмт хэрэг хүлээлгэх ял шийтгэл нь торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялаас бүрдэж байгаа ба энэ гэмт хэргийг үйлдсэн этгээдийн 90 орчим хувьд торгох ялыг, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээний хамт оногдуулж шийдвэрлэж байна.

Шүүхээс энэ гэмт хэрэгт ял оногдуулахдаа эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийг баримтлан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулах зохицуулалтыг өргөн хэрэглэж байгаа юм.

Тэр дундаа гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн буруутай этгээдийн өмчлөлд байсан

нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулдаг.

Харин торгох ялын тухайд зах зээлийн нөхцөл байдал болон шүүгдэгчийн хувийн байдалд тохируулан оногдуулж байгаа үндэслэлд тулгуурлан торгох ялын биелэлт 98 хувийн биелэлттэй байдаг бол хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодитой биелэлт хангалттай бус байгаа нь анхаарал татаж байна.

Олон улсад эд хөрөнгө хураах ялын ойлголтыг хүний эд хөрөнгөтэй байх, өмчлөх эрх буюу хүний жам ёсны суурь эрхийн эсрэг үйл ажиллагаа гэж үздэг бөгөөд орчин цагийн дэлхийн эрүүгийн ялын бодлого, эрүүгийн эрх зүйн реформын хүрээнд энэ төрлийн ялаас олон улс татгалзах чиг хандлагатай байна. Харин гэмт хэрэг үйлдэж олсон болон гэмт хэрэг үйлдэх үедээ ашигласан хөрөнгө, орлого, эд зүйлсийг хураан авах албадлагын арга хэмжээ хэлбэрээр авч хэрэгжүүлэх ойлголт олон улсын эрх зүйд өргөн хэрэглэгдэж байна.

Дэлхийн хөгжингүй болон өндөр хөгжилтэй ихэнх оронд эд хөрөнгийг хэсэгчлэн хураах ойлголтыг тайлбарлах талаар нэгдсэн үзэл санаа хараахан бий болоогүй ажээ. Гэхдээ харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн практик, жишгийг бий болгосон байдгийг харж болно.

Австри, Англи, Герман, АНУ, Швейцарь, Парагвай зэрэг зарим оронд эд хөрөнгө хураах санкцийг дараах 2 үндсэн хэлбэрээр оноож хэрэглэж иржээ. Үүнд:

1. Гэмт үйлдлээр шууд олж авсан материаллаг эд зүйлс, түүгээр дамжин бий болгосон ашиг орлогыг албадан хурааж авах

2. Гэмт үйлдлийн багаж зэвсэг, техник хэрэгслийг хураан авах г.м

Түүнчлэн Испани, Исланд, Литва, Марокко, Молдав, Румын Хорват, Австри, Германд эд хөрөнгө хураах нь ял биш харин эрүүгийн нөлөөллийн арга хэмжээ гэж тооцогддог. Жишээ нь: Серб, Македон, Хорват зэрэгт гэмт хэргийн улмаас олсон эд зүйлсийг хураах нь эрүүгийн ялын нэмэгдэл санкц болгон хэрэглэдэг бол харин гэмт хэрэг хийхэд ашигласан багаж зэвсгийг хураах нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээ болдог. Харин хэсэгчлэн эд хөрөнгө хураах явдлыг эрүүгийн нэмэгдэл ял гэж үзэн хэрэглэж буй голлох төлөөлөгч орнуудад Франц, Япон, Туркменстан, Албани, Азербайджан, Филиппин, Эстон зэргийг дурдаж болно.

Аливаа орны эрүүгийн эрх зүйд эд хөрөнгө хураах хэлбэртэй хариуцлага, шийтгэлийн төрлүүд байдаг бөгөөд Монгол Улсад эд хөрөнгө хураах асуудлыг 2002 оны Эрүүгийн хуулиар ялын төрөлд хамааруулан авч үзэж байсныг өөрчлөн 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад албадлагын арга хэмжээний төрөлд хамааруулан хуульчилсан юм.

Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө,

орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулж байгаа төрийн албадлагын нэг хэлбэр юм.

Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь дараах шинжтэй.

- Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлого байх
- Бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилго агуулдаг
- Гэм буруутай хүн, хуулийн этгээдийн хувьд ноогдох, хөрөнгө орлого

байх

- Хариу төлбөргүйгээр албадан хураан авах зэрэг болно.

Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрт заасан хөрөнгө, эд зүйлийг албадан гаргуулж, төрийн байгууллагад шууд шилжүүлэх эсхүл худалдан борлуулж түүний үнийг улсын төсөвт төвлөрүүлэх хэлбэрээр гүйцэтгэдэг онцлогтой.

Хууль бусаар барааг улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэргийг үйлдэхэд гол ашиглагддаг эд хөрөнгө бол гол төлөв тээврийн хэрэгсэл, машин механизм байдаг. Иймд тээврийн хэрэгслийг төрийн өмчлөлд шилжүүлэх эсхүл түүний үнийг улсын орлогод төвлөрүүлэх шаардлагатай.

Машин механизм болон тоног төхөөрөмж гэж гэм буруутай этгээд тухайн гэмт хэргийг үйлдэхдээ учруулж болох хор аюулын хэмжээг ихэсгэх, гэмт үйлдлээ түргэсгэх, олж авсан эд зүйлсийг зөөж тээвэрлэх, гэмт хэргийн газраас зугтах зорилгоор хэрэглэсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан бүх төрлийн тээврийн хэрэгсэл, гэмт үйлдлээ хялбар болгох, хохирогчийн эсэргүүцлийг няцаах, учирч болох саадыг арилгахын тулд ашигласан төрөл бүрийн тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай, хордуулах бодис, хориотой үйлдвэр, үйлчилгээ явуулсан техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, барилга, байгууламжийг ойлгоно.

Сүүлийн 5 жилийн байдлаар эрүүгийн хуулийн 18.5-д заасан гэмт хэрэгт оногдуулсан шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзвэл шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 2.5-д зааснаар эд мөрийн баримтаар хураагдсан уаз фургон машиныг “Өмнөговь аймгийн Байгаль хамгаалах санд оруулах”-аар шийдвэрлэжээ. Мөн 2020 оны шүүхийн дугаар шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт “Эрүүгийн хуулийн ерөнхий 7.5 дугаар зүйлийн 1, 2, 5 дахь хэсэгт заасныг баримтлан хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн хонины мах 272 кг, үхрийн 473 кг, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан Истана маркийн тээврийн хэрэгслийн үнэ болох 6,524,920 төгрөгийг ялтан Ж-ээс гаргуулж улсын орлого болгосугай” гэж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт №1. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгт холбогдуулан хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тоон үзүүлэлт

Он	Нийт	Үлдэгдэл
2021	53	6
2022	89	4
2023	22	2
2024	2	1
	166	13

Эдгээрээс үзвэл хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэрэгсэл болж байна.

Ийнхүү уг гэмт хэрэгт эрүүгийн хуульд заасан ял болон албадлагын арга хэмжээг хослуулан хэрэглэж байгаа нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангаж байгаа хэрэг юм.

2021-2024 оны байдлаар зарим хилийн боомт бүхий бүсүүдэд үйлдэгдсэн “улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх” гэмт хэрэгт оногдуулсан хэд хэдэн шүүхийн шийдвэрт хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг гүйцэтгэх талаар дурджээ.

Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх үед хураагдсан эд хөрөнгө, эд зүйлийг шийдвэр гүйцэтгэгч нь иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх журмын дагуу гаргуулдаг бол галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт бодис зэрэг тусгай зөвшөөрлөөр олж авах эд зүйлийг шүүхийн шийдвэрийн дагуу холбогдох байгууллагад худалдаж, эсхүл шилжүүлж шийдвэрлэж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тоон үзүүлэлтийг харахад хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бодит биелэлт 90 орчим хувьтай байгаа боловч эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бүрэн бодитой биелэгдэх, шуурхай байх зарчмууд алдагдаж байгааг дээрх үлдэгдэл гүйцэтгэх баримт бичгүүд илтгэж байна. Тэгвэл үлдэгдэл буюу өнөөдрийн байдлаар биелэгдээгүй байгаа 13 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэхэд тулгамдаж буй асуудлын шалтгаан нөхцөлийг тодорхойлж үзэх нь зүйтэй юм.

Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд практикт хэд хэдэн тулгамдсан асуудлууд үүсээд байна. Үүнийг төрөлжүүлэн авч үзвэл дараах байдлаар ангилж болно. Тухайлбал:

1. Хураагдсан хөрөнгийн шинж чанар алдагдах эрсдэл

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас эхлээд прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үе шатуудад аливаа хөрөнгө эд зүйлсийг хураан авах, түүний хадгалалт хамгаалалт, стандарт нөхцөлийг заасан, баримталсан зүйл практикт байхгүй байна. Үүнээс үүдэлтэйгээр хөрөнгийн шийдвэрлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодитой биелэлтэд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал бий болж байна. Үүнд:

А. Тээврийн хэрэгсэл: Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгт ихэнх тохиолдолд гэмт хэрэг үйлдэхэд ашигласан техник хэрэгсэлд тээврийн хэрэгсэл битүүмжлэгдэн хураагдаж, түүнийг улсын орлого болгох асуудал тулгардаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн тээврийн хэрэгслийг битүүмжлэхдээ гэмт хэрэгт холбогдсон этгээдэд хадгалалт хамгаалалтыг хариуцуулах асуудал түгээмэл байна. Гэвч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэрэгт холбогдсон этгээдэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шаардлага үүсдэг. Энэ тохиолдолд тухайн битүүмжлэгдсэн тээврийн хэрэгслийн хадгалалт, хамгаалалтын асуудал эзэнгүй үлдэж үүнээс үүдэлтэйгээр тээврийн хэрэгсэл тоногдох явдал гарсаар байна. Нэгэнт тоногдсон тээврийн хэрэгслийн зах зээлийн үнэлгээг тогтоох, түүнийг улсын орлого болгоход анх үнэлсэн болон шүүхийн шийдвэрээр тогтоосон үнэлгээнд хүрэхгүй байх, түүнийг ханган шийдвэрлэх боломжгүй нөхцөл үүсдэг.

Б. Ургамал болон амьтны гаралтай эд зүйлс: Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдуулан Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд зааснаар эмийн ургамал, амьтны гаралтай эд зүйлс буюу эвэр, туурай, арьс, баавгайн савар, агнасан чоно гэх мэт зүйлсийг хураах тохиолдол цөөнгүй байна. Хураасан дээрх зүйлсийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ямар нөхцөлд хэрхэн хадгалах талаар шийдвэрлэж, зааварласан, зөвлөсөн шийдвэр практикт аль ч шатанд байхгүй байгаа нь тухайн эд зүйлсийн шинж чанарыг алдагдуулах, муутгах, үнэгүйдүүлэх эрсдэлийг мөн үүсгээд байгаа юм. Жишээ нь дэрвэгэр жиргэрүү ургамлын үндсийг ямар нөхцөлд, хэрхэн хадгалах талаар мэргэжлийн байгууллагын заавар зөвлөмж байхгүй байгаа тул агуулах, саванд хадгалах хэлбэрээр хадгалж түүнээс үүдэлтэй борооны усанд норох, хөгцрөх, жингийн алдагдалд орох гэх мэт зах зээлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх нөхцөлүүдийг үүсгээд байна.

2. Хөрөнгийг хадгалах, хамгаалах байр, агуулах сав:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар битүүмжилсэн, хураасан эд хөрөнгийг тусгай зориулалтын байранд хадгалуулна гэж заасан боловч ийм төрлийн хадгалах байртай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага байхгүй байна.

Тусгай зориулалтын байр нь онцгой бараа бүтээгдэхүүн эд зүйлсийг хадгалах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх шаардлагыг дотроо агуулна. Гэвч хууль болон журмаар тэрхүү тусгай зориулалтын байрны стандартыг тогтоосон зүйл байхгүй байгаагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагууд дотооддоо сул, чөлөөтэй өрөө тасалгаагаар хөрөнгө хадгалах асуудлыг шийдвэрлэх хэлбэртэй байна. Хөрөнгийг хадгалах тусгай зориулалтын байрны стандарт байхгүйгээс дээр дурдсан хөрөнгийн шинж чанар алдагдах эрсдэлийг давхар үүсгэж байгаа юм.

3. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 299 дүгээр зүйл 299.5-д заасны дагуу Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд холбогдуулан гарах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Энэхүү зарчмын хүрээнд ШШГЕГ-ын харьяа газар, хэлтсүүд нэгжийн төсөвт энэ төрлийн ШГА-ны зардлыг тусгуулах шаардлагатай байдаг. Гэвч өнөөдрийн байдлаар зардлыг тодорхой шийдвэрлэсэн журам байхгүй. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны алхам тутамд зардлын тулгамдсан асуудлууд өнөөдрийг хүртэлх хугацаанд үргэлжилсээр байна.

Жишээлбэл: Хил орчмын бүс нутагт саатуулагдсан тээврийн хэрэгслийг аймгийн төвд байрлах Шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүлээлгэж өгөх, авч ирэх тээврийн зардлын асуудал шийдвэрлэхэд төвөгтэй өртөг өндөртэй байдагтай холбоотойгоор шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хугацаа алдах түүнээс болж хөрөнгийн бүрэн бүтэн байдал алдагдах эрсдэлийг хүлээж байна. Бодит байдал дээр хилийн бүс нутгаас аймгийн төв хүртэлх зай нь ойролцоогоор 100-350 км байх нь элбэг тохиолдоно. Мөн бүрэн бус тээврийн хэрэгслийг тээвэрлэх, ачих үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын асуудлаас болж шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байх зарчим мөн алдагдаж байгаа юм.

4. Улсын орлого болгох зорилгоор төрийн холбогдох байгууллагад шилжүүлэх тухай:

Энэхүү нэр төрлийн гэмт хэрэгтэй холбоотойгоор олон төрлийн эд зүйлсийг шийдвэрлэх шаардлага өнөөгийн нийгэмд үүссэн байхад энэ төрлийн харилцааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 191 дүгээр зүйлд заасан “...холбогдох байгууллагад шилжүүлэх” гэсэн хэт ерөнхий зохицуулалтаар шийдвэрлэж байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүндрэл учруулсаар байна.

Албадлагын арга хэмжээний хүрээнд хураан авсан амьтны гаралтай эд зүйлийг холбогдох байгууллагад шилжүүлнэ гэхээр байгаль орчны газарт хүргүүлэх үү? Аль эсвэл улсын музейд шилжүүлэх үү? Ямар шалгуур үзүүлэлтээр холбогдох байгууллагыг тодорхойлох эсэх нь мөн адил тодорхойгүй байгаа юм. Дээрх хэт ерөнхий зохицуулалтаас үүдэлтэйгээр шийдвэр гүйцэтгэгч тухайн холбогдох байгууллагыг эрж тогтоох, санал хүргүүлэх, тухайн саналыг хүлээн авсан байгууллага хэрхэн шийдвэрлэх талаар нэгдсэн ойлголтгүйгээс хураасан эд зүйлсийн шийдвэрлэлт удаашралтай явагдаж байна.

Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг улсын орлого болгож, улсын төсөвт оруулахтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нарийвчлан зохицуулсан журам өнөөдрийг хүртэл байхгүй байна.

Дүгнэлт

1. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг нь Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох улсын хилийн халдашгүй байдлыг хангах, цаашлаад Монгол Улсын байгалийн баялаг, Үндэсний өв соёлыг хамгаалахад ч нөлөө үзүүлж болох тул энэ гэмт хэргийн үйлдлийн арга, түүнд оногдуулах эрүүгийн хариуцлага, хариуцлагын биелэлтэд ихээхэн анхаарах шаардлага тулгарч байна.

2. Энэ төрлийн гэмт хэргийн 90 орчим хувьд торгох ялыг хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээний хамт авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэж байна. Торгох ялын биелэлт хангалттай байгаа боловч хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээний бодит биелэлт эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хангахгүй байгаа нь анхаарал татаж байна.

3. Хураасан хөрөнгийн шинж чанарыг алдагдуулахгүй байх талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хангалттай авч хэрэгжүүлэхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтэд сөргөөр нөлөөлж байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хөрөнгийг битүүмжлэх, хураах үедээ тогтоолд хөрөнгийн шинж байдлыг бичихгүй байх, хөрөнгийн хадгалагч хамгаалагчийг тогтоохгүй орхих, эсхүл гэмт хэрэгт холбогдсон этгээдэд өөрт нь хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг хариуцуулж байгаа нь тухайн хөрөнгийн бүрэн бүтэн байдал болоод хөрөнгийг үнэгүйдүүлэх зэргээр сөрөг үр дагавруудыг учруулсаар байна.

4. Хураасан хөрөнгө, эд зүйлсийг хадгалах тусгай зориулалтын байрны стандарт байхгүйгээс хөрөнгийн хадгалалт хамгаалалт шаардлага хангахгүй байна. Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болохын хувьд улсын төсвөөс санхүүжих шаардлагатай хэдий ч энэ төрлийн ажиллагааны зардлыг зохицуулсан журам байхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байх, бүрэн бодитой биелэгдэх зарчмыг алдагдуулж байна.

5. Хураагдсан эд зүйлсийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар “холбогдох байгууллагад шилжүүлнэ” гэсэн зохицуулалт нь хэт ерөнхий байгаа тул шууд шийдвэрлэх боломжгүй нөхцөлийг тус тус бүрдүүлж байна.

Санал

1. Шүүхийн шийдвэрт улсын орлогод оруулахаар шийдвэрлэсэн онцгой бараа бүтээгдэхүүнийг хадгалах, хамгаалах арга журам, стандартыг мэргэжлийн байгууллагын заавар зөвлөмж мэдээллийн хамт тусгаж өгөх,

2. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх арга, журмыг тодорхой болгох

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эд хөрөнгийг хадгалах агуулах, байрны стандартыг тогтоож хуульчилж өгөх ,

4. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээгээр гаргуулсан эд хөрөнгө, эд зүйлсийг улсын орлого болгох улсын төсөвт төвлөрүүлэх тухай журам боловсруулах гэсэн саналтай байна.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992 он. №01
- Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2002 он. № 05
- Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2015 он. №07
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017 он. №24
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. УБ., 2015 он. №28
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол Улсын Их хурлын тогтоол. УБ., 2010 он №48
- Г.Гантөмөр, С.Гантулга нар. Эрүүгийн эрх зүй ерөнхий ангийн сурах бичиг. УБ., 2020 он.
- С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй тусгай ангийн тусгай анги. УБ., 2018 он.
- Б.Батцэрэн, Э.Амарбат нар. Эрүүгийн хууль сургагч багшийн гарын авлага. Хууль зүй Дотоод хэргийн яам. УБ., 2017 он.
- Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй., УБ. 2017 он.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2021 он.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар,.Шийдвэр гүйцэтгэх албаны мэдээ, судалгаа (2017-2021)
- Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2020, 2021, 2022, 2023 2024 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. <http://police.gov.mn/>
- Чөлөөт нэвтэрхий толь-Википедиа. <http://mn.wikipedia.org/>
- Шүүхийн шийдвэрийн цахим сан. <http://new.shuukh.mn/>